



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#3 (24)

Сар тутмын хэвлэл

<http://www.mnier.mn>

IV сар

УРЛАГ

(Нүүр 3-4)



ТЕХНОЛОГИ

(Нүүр 5)



МАТЕМАТИК

(Нүүр 6-7)



БАЙГАЛИЙН УХААН

(Нүүр 9)



БИЕЙН ТАМИР, ЭРҮҮЛ МЭНД

(Нүүр 10)



МОНГОЛ ХЭЛ

(Нүүр 11-12)



ГАДААД ХЭЛ

(Нүүр 12-13)



НИЙГМИЙН УХААН

(Нүүр 13)



“СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР” ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Монгол Улсын боловсролын их сургууль, Боловсролын ерөнхий газар хамтран Монголын багш нарын VIII их хурлыг угтан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр” сэдэвт үндэсний хэлэлцүүлгийг 2024 оны 4 дүгээр сарын 2, 4, 5-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт 21 аймаг, 9 дүүргийн СӨБ болон ЕБС-ийн монгол хэл, математик, байгалийн ухаан, нийгмийн ухаан, урлаг, технологи, биеийн тамир, эрүүл мэнд, гадаад хэлний багш нар болон СӨБ-ийн арга зүйч, багш бэлтгэх их дээд сургуулийн төлөөлөл бүхий 800 гаруй оролцогч хамрагдлаа.



Шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжил, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд гарч буй гэнэтийн өөрчлөлт зэргээс үүдэж боловсрол хувьсаж байна. Үүнийг дагаад сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах хэрэгцээ шаардлага тулгарч байгаа билээ. Тиймээс үндэсний болон дэд чуулганыг үе шаттайгаар зохион байгуулж хөтөлбөрийн шинэчлэл, үзэл баримтлалын чиглэлээр багш нарын саналыг сонсож байгаа билээ.



Үндсэн илтгэлд “Боловсролын шинэ сэргэлт” сэдвээр БШУ-ы сайд Л.Энх-Амгалан, “Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрийн үзэл баримтлал” сэдвээр Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал М.Итгэл, “Багш бэлтгэх хөтөлбөрийн шинэчлэл” сэдвээр Монгол Улсын Боловсролын их сургуулийн ректор Ж.Батбаатар нар боловсролын салбарт хийгдэж байгаа шинэчлэлийн бодлого чиглэлийг танилцууллаа.

Улмаар оролцогчид суралцахуйн хүрээний чиглэлээр 8 салбар хэлэлцүүлэгт хуваагдаж, сургалтын хөтөлбөр, багшийн хөгжил, багш бэлтгэх хөтөлбөрийн чиглэлээр хэлэлцүүлэг өрнүүлж, асуудлаа тодорхойлж, шийдвэрлэх үр дүнтэй арга замуудыг хэлэлцэн, Монголын багш нарын VIII их хуралд өргөн барих саналын төслийг гаргасан юм.



Энэхүү хэлэлцүүлэг нь сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал батлагдах, сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахын өмнө болж, багш нарын бодит саналыг сонсож, цаашдын үйл ажиллагаанд тусгах боломжийг бий болгосноороо ач холбогдолтой болсон юм.

"УРЛАГ" СУРАЛЦАХУЙН ХҮРЭЭ

Дэлхийн болон Монгол Улсын боловсролын хөгжлийн бодлого чиглэл, нийгмийн болон хувь хүний хэрэгцээнд үндэслэн дэлхийн болон үндэсний өв соёлыг өвлөн эзэмшдэг, эх дэлхийгээ хайрлан хамгаалдаг, аливаа асуудлыг шүүн тунгааж, бүтээлчээр шийдвэрлэдэг, хариуцлагатайгаар хамтран ажилладаг, ёс суртахуунтай, эрүүл, насан туршдаа суралцах чадвартай иргэнийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг боловсруулан хэлэлцүүлж байна.

2024 оны 03 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Монголын боловсролын хувирган өөрчлөлт-2024 үндэсний чуулганы үргэлжлэл "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр" сэдэвт үндэсний хэлэлцүүлэг аймаг, нийслэлийн дүрслэх урлаг, хөгжмийн нийт 100 орчим багшийн төлөөллийг хамруулан зохион байгуулагдлаа.



"Урлаг" салбар МУБИС-ийн ДУТС-ийн захирал С.Батцоож удирдан, хэлэлцүүлгийн зорилго, агуулгыг танилцуулаад, үндэсний түвшинд, багш бэлтгэх түвшинд, сургууль, багшийн түвшинд тулгамдаж буй асуудал, шийдлийн талаар оролцогчдыг саналаа хэлэхийг хүслээ.

Энэхүү хэлэлцүүлгийн зорилго нь Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, суурь үндэслэлийг багш нарт танилцуулах, санал бодлыг сонсох, гарсан үр дүнг Монголын багш нарын VIII их хуралд өргөн барих явдал байсан.

ТҮҮНЧЛЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ОРОЛЦОГЧИД

1. Аж үйлдвэрийн IV хувьсгал, 21 дүгээр зууны хувьсал, технологийн хурдтай өөрчлөлтөд сургууль, багш, суралцагч өөрчлөлтөд бэлэн үү?
2. Урлаг судлагдахуун суралцагчийн ямар чадамжийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна гэж үзэж байна вэ?
 - Тухайн чадамжийг суралцагчдад эзэмшүүлэхэд ямар үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх вэ?
 - Бид юунаас эхлэх хэрэгтэй вэ? Хүүхдэд тулгамдаж буй асуудал юу байна вэ?
 - Бидний хийж хэрэгжүүлэх ажил юу байх вэ?
 - Хөтөлбөрийн шинэчлэлийг хийхэд бидэнд тулгарах асуудал, бэрхшээл, шийдэх арга зам юу байх вэ?
 - Суралцахуйн хүрээг тодорхойлохын ач холбогдол юу вэ?

Дээрх асуултын хариултыг хамтдаа хэлэлцэн, санал солилцсон нь хэлэлцүүлгийн үр дүн байна гэж үзсэн.



Урлагийн суралцахуйн хүрээтэй холбоотой дараах асуудал шийдлийг оролцогчид дэвшүүлээ. Салбар хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэж үзэхэд



АСУУДАЛ:

- Боловсролын түвшин хоорондын уялдааг сайжруулах
- Сургалтын орчин, нөхцөлийг сайжруулж, хэрэглэгдэхүүнээр хангах (СӨБ-ийн багш нарт сурах бичиг байхгүй)
- Хүүхдийн түвшинг тодорхойлох, хөгжлийн онцлог болон цаг үе нийгмийн хөгжилд тулгуурлан хичээлээ төлөвлөх, түвшинд нь тохирсон үйл ажиллагааг хэргэжүүлэх
- 1-9 ангид дүрслэх урлагийн хичээлийг оруулах
- Бага ангид мэргэжлийн багшаар дүрслэх урлагийн хичээлийг заалгах
- Дугуйлангийн цагийг багшийн үндсэн цагт тооцдог болох



ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖ:

ҮНДЭСНИЙ ТҮВШИНД

- Судалгаа хийх
- Хувь хүн, нийгмийн хөгжил, хэрэгцээг харгалзах
- Боловсролын түвшин хоорондын агуулгын залгамж холбоог сайжруулах
- СӨБ-оос эхлэн дүрслэх урлагийн хичээлийг мэргэжлийн багшаар заалгах
- СӨБ-ийн багш нарын арга зүйд дэмжлэг болох сурах бичигтэй байх боломжийг судлах

ОРОН НУТГИЙН ТҮВШИНД

- Сургалтын орчин, нөхцөлийг сайжруулах төсөл, хөтөлбөрт хамрагдах
- Үзэл баримтлал, алсын хараанд нийцүүлэн орон нутгийн онцлогтой хөтөлбөр хийж хэрэгжүүлэх

СУРГУУЛИЙН ТҮВШИНД

- Суралцагчийн түвшинг тодорхойлох, түүнд тохирсон үйл ажиллагааг төлөвлөх
- Сургалтын орчин, нөхцөлийг сайжруулахад сургуулийн удирдлага анхаарах
- Нөхцөл байдалдаа тохируулан үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх
- Сургалтыг илүү үр дүнтэй, практик дадлага хийхээр зохицуулах

"ТЕХНОЛОГИ" СУРАЛЦАХУЙН ХҮРЭЭ



2024.04.02-ны өдөр Улаанбаатар хотноо “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр” -ийн шинэчлэлттэй холбоотой үндэсний хэлэлцүүлэг амжилттай зохион байгуулагдлаа. Тус хэлэлцүүлгийг БСҮХ, МУБИС, БЕГ хамтран зохион байгуулж хот хөдөөгийн 80 гаруй дизайн болон мэдээллийн технологийн багш сурган хүмүүжүүлэгчид оролцон хөтөлбөрийн шинэчлэлттэй холбоотой суралцахуйн хүрээний асуудлууд дээр санал бодлоо солилцон ажиллалаа. Дэд хэлэлцүүлгийн үеэр 3 байгууллагын мэргэжилтнүүд 3 үе шаттай хэлэлцүүлгийг зохион байгуулж багш төлөөллүүдийн саналыг авч харилцан мэдээлэл солилцон хэлэлцлээ. Үүнд:

**Суралцахуйн
хүрээ - БСҮХ**

Багшийн хөгжил - БЕГ

**Багш бэлтгэх хөтөлбөрийн
шинэчлэл - МУБИС**

БСҮХ-ээс удирдан чиглүүлсэн технологийн суралцахуйн хүрээний судлагдахуунуудтай холбоотой практик асуудал, шийдлүүд, хөтөлбөрийн хэрэгжилт, сайжруулах саналууд, цаашид анхаарвал зүйтэй асуудлууд, тэдгээрийн боломжит гаргалгааг хэлэлцэн гарган тавьж мэргэжлийн хүрээгээрээ хэд хэдэн санал шийдлийг санал болгосон билээ.



Хэлэлцүүлгээр судлагдахууны хүрээний ач холбогдол, тулгарч болзошгүй сорилт бэрхшээл, шийдвэрлэх боломжуудыг тодорхойлон “Технологи” суралцахуйн хүрээнд боловсролын түвшин бүрд ямар хичээл /судлагдахууны боломжит хувилбарууд байж болохыг тодорхойлон гаргаж тавьсан. Судлагдахууны хүрээтэй холбоотойгоор цаашид VR технологийг хөгжүүлэх, дизайн зураг зүйн хичээл дээр инженерчлэлийн программ хэрэглэх, механик электрон дээр IT, Coding нэмэх, сургалтын орчинг тогтвортой болгож төсөл хөгжлийг дэмжих, багш бүрийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх, агуулгаа багасгах, зарим агуулгатай интеграцилах, мэргэжлийн бүлгээр хамтран суралцах, багш хөтөлбөр сайжруулах, хамтын хичээлийг туршин боловсруулах, хичээлийн цагийг нэмэгдүүлэх зэрэг саналуудыг дэвшүүллээ. Мөн бүх түвшний боловсролд технологийн суралцахуйн хүрээнд хэрэгжүүлж болох судлагдахууны хувилбаруудын саналыг тэмдэглэн хөтөлбөр боловсруулахад тусгахаар нэгтгэлийг хийлээ.

"МАТЕМАТИК" СУРАЛЦАХУЙН ХҮРЭЭ



"Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"-ийг танилцуулах, "чадамжид суурилсан хөтөлбөр", "суралцахуйн хүрээ"-ний талаар мэдээлэл хүргэх, багш нарын саналыг сонсох зорилготой хэлэлцүүлэг амжилттай зохион байгуулагдлаа. Тус хэлэлцүүлэгт нийслэл, орон нутгийн математикийн багш нарын төлөөлөл 94, БСҮХ, БЕГ, МУБИС-ийн 10 оролцогч нийт 104 хүн оролцов.




Салбар хэлэлцүүлгийн ерөнхий чиглүүлэгчээр БСҮХ-ийн ЭША Ж.Дэнсмаа ажиллаж "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"-ийг танилцуулж, ЭША О.Нацагдорж, Б.Эрдэнэчимэг, Б.Баасанжаргал нар хамтран ажиллаж, хэлэлцүүлгийг хамтран зохион байгууллаа. Дэд хэлэлцүүлгийн хүрээнд дараах чиглэлээр мэдээлэл өгч, багш нарын дунд хэлэлцүүлэг өрнүүлэн, саналыг нэгтгэв. Үүнд:



- Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд туссан чадамжуудыг математикийн сургалтын хөтөлбөрт тусгах шаардлагатай эсэхийг тандсан санал асуулга
- Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хийхэд бидэнд тулгарах сорил бэрхшээл, шийдвэрлэх боломж
- Боловсрол дахь цахим шилжилтийн нэг хэсэг болох цахим сурах бичгийн талаар, тэр дундаа **Learnetic** компанитай хамтран хэрэгжүүлж буй бага ангийн сурах бичгийг цахим хэлбэрт шилжүүлж буй ажлын явц

Санал асуулгыг сургалтын эхэнд цахимаар авч нэгтгэсэн бөгөөд асуулгад хариулсан 89 оролцогчийн 50-аас дээш хувь нь бүтээлчээр сэтгэх, бие даан болон хамтран ажиллах, амьдрах, шүүн тунгаах, цахим технологи хэрэглэх, суралцахууд суралцах, харилцах зэрэг чадамжийг заавал тусгах шаардлагатай гэж үзсэн байна. Энэ нь хөтөлбөрийн үзэл баримтлалтай нь санал нийцэж байгааг харуулж байна.

Зураг 1. Математикийн сургалтын хөтөлбөрт тусгах чадамжийн талаарх оролцогчдын санал



Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хийхэд тулгарах сорил бэрхшээл, шийдвэрлэх боломжийн талаар үндэсний болон орон нутаг, сургуулийн түвшинд ямар байх талаар хэлэлцэж, 9 баг тус бүр саналаа нэгтгэн танилцууллаа. Хэлэлцүүлэгт багш нар маш идэвхтэй оролцож чухал саналуудыг гаргасан ба саналын нэгтгэлийг хэлэлцүүлгийн нэгдсэн саналд оруулсан. Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах давуу талтай гэж зөвлөгөөнд оролцогчдын олонх нь үзэж байна. Тухайлбал:

- СӨБ-оос БДБ-ын төгсгөл хүртэл 9 чадамжийг тасралтгүй, залгамж холбоотойгоор хөгжүүлэхээр томъёолсноор боловсролын бүх түвшинд зорилго тодорхой болж, оролцогч талууд нэг ойлголтойгоор хамтран ажиллах нөхцөл, боломж илүү сайжирна.
- Судлагдахуун хоорондын интеграц сайжирч сурагчийн бие даан суралцах, бүтээлчээр сэтгэх, шүүн тунгаах, хариуцлагатай хүндлэлтэй байх, сэтгэл хөдлөлөө удирдах, илэрхийлэх, мэдлэг, чадвараа хэрэглэх, тайлбарлан ярилцах гэх мэт чухал чадвар, чадамжууд хөгжих нөхцөл бүрдэнэ.
- ТХБ-ын зорилтууд хэрэгжих боломж бүрдэнэ гэх мэт.



АСУУДАЛ:

- Шинэчлэлтэй холбоотой нэрт томъёо, ойлголтуудыг нэр утгаар ойлгож, хэрэглэх тал дээр асуудал үүсдэг
- Чадамжуудыг судлагдахууны хөтөлбөрт буулгах, чадамжийг хөгжүүлэх арга зүйн хувьд бэрхшээл тулгарна. Өөрөөр хэлбэл шинэ арга зүй, нөхцөлд багш, сурагч, эцэг эх дасан зохицоход асуудал үүснэ.
- Сургалтын орчин нөхцөл бүрдээгүй, анги дүүргэлт, дэд бүтцийн асуудлууд зэрэг сургуулийн байршил, орчин нөхцөлтэй холбоотой асуудлууд хөтөлбөрийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлдэг тул үүнийг бодолцох шаардлагатай.
- Багш нарт онол, арга зүй, сэтгэл судлалтай холбоотой асуудлууд үүснэ.
- Бодлогын тавил, заах арга зүйтэй холбоотой нэлээд өөрчлөлт хийгдэх тул түүнд суралцах, багшаа бэлтгэх асуудал үүснэ.



ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖ:



ҮНДЭСНИЙ ТҮВШИНД

- Оролцогч талууд бүгд ойлголтоо нэгтгэх
- Зөвлөмж гарын авлага, мэргэжил дээшлүүлэх тогтолцоогоор дамжуулан багш нар, мэргэжлийн байгууллагуудын ойлголтыг нэгтгэх, бэлэн байдлыг хангах
- Үнэлгээний агуулга, арга зүй, сурах бичиг боловсруулахдаа шинэчлэлийн гол үзэл санаа (чадамжид суурилсан)-тай нягт уялдуулах
- Орон нутгийн онцлогтой хөтөлбөр хэрэгжүүлэх боломж, чадамжийг бүрдүүлэх
- Багш бэлтгэх сургуулийн хөтөлбөр, арга зүй, үйл ажиллагаанд одооноос шинэ үзэл санааг шингээж оруулах, хөрвөх чадвартай багш бэлтгэх
- Орчин нөхцөл, хэрэглэгдэхүүний хүрэлцээ хангамжийг сайжруулах

ОРОН НУТГИЙН ТҮВШИНД

- Ойлголтоо нэгтгэх
- Багшийг чадавхжуулахад орон нутгийн түвшинд бодлого гаргаж, хэрэгжүүлэх. Үүнд: орон нутгийн аргазүйч, мэргэжилтнүүдийг чадавхжуулж, мэргэжилтнүүд мэргэжил дээшлүүлэх, хамтран хөгжих үйл ажиллагааг чиглүүлэн манлайлж ажиллах, орон нутагт танхимын сургалтуудыг чанартай зохион байгуулах
- Мэргэжлийн хөгжлийн бүлэг, сургагч багш нарын үйл ажиллагааг сайжруулах, хамтран ажиллах нөхцөл бүрдүүлэх
- Багш, боловсон хүчний нөөцтэй болох, хангах
- Интернэт болон бусад орчин нөхцөлийг сайжруулах
- Сайн туршлага, шилдэг санааг түгээн дэлгэрүүлэх, хамтран суралцах

СУРГУУЛИЙН ТҮВШИНД

- Ойлголтоо нэгтгэх
- Сургуулийн менежментийг сайжруулах
- Сургууль бүр өөрийн онцлогт тохирсон хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх
- Сургалтын менежер арга зүйн чадвартай байх, чиглүүлэх
- Суралцагчид сурах, багш нар ажиллах таатай орчин бүрдүүлэхэд санаачилгатай ажиллах (материаллаг болон сэтгэл зүйн)

Салбар хэлэлцүүлгийг зохион байгуулсан багийн зүгээс хэлэлцүүлэг зорилгоо хангасан, үр дүнтэй боллоо гэж дүгнэж байна.

"БАЙГАЛИЙН УХААН" СУРАЛЦАХУЙН ХҮРЭЭ



"Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"-ийг танилцуулах, үндэсний хэмжээнд байгалийн ухааны багш нарын чадамжид суурилсан хөтөлбөр, суралцахуйн хүрээнд хамаарах судлагдахууны (физик, хими, биологи, газарзүй) багш нараас санал авах зорилготой хэлэлцүүлэг амжилттай зохион байгуулагдлаа.

Тус хэлэлцүүлэгт нийслэл, орон нутгийн багш нарын төлөөлөл нийт 120 гаруй хүн оролцов. Дэд хэлэлцүүлгийн эхэнд БСҮХ-ийн ЭША Б.Алтансүх "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал"-ийг танилцуулж, ЭША С.Цогбадрах, Г.Баянчимэг нар дараах агуулгын хүрээнд 10 багт хувааж, хэлэлцүүлгийг удирдан чиглүүлэв. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд тусгагдсан чадамжийг хөгжүүлэхэд байгалийн ухааны суралцахуйн хүрээний хувь нэмэр
- Чадамжийг хөгжүүлэхэд тулгарах сорилт бэрхшээл, шийдвэрлэх боломж
- Байгалийн ухааны суралцахуйн хүрээнд хамаарах судлагдахуун /түвшин бүрээр/

Дээрх агуулгын хүрээнд баг тус бүрээс гарсан сорил бэрхшээл, шийдвэрлэх боломж, сайжруулах саналуудыг үндэсний түвшинд, орон нутгийн түвшинд, сургуулийн түвшинд ангилан нэгтгэв.

ҮНДЭСНИЙ ТҮВШИНД:

- Хөтөлбөрийн хувьд боловсролын түвшин хоорондын агуулгын залгамж холбоог сайжруулах, үндэсний соёл, уламжлалыг байгалийн ухааны суралцахуйн хүрээтэй холбон сурталчилсан контент, платформ хийх, сурах бичигт тусгаж өгөх
- Сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хувьд орчин, нөхцөлийг сайжруулах, тоо ширхэг хүртээмжийг нэмэгдүүлэх, экскурс хичээл зохион байгуулах боломжийг бүрдүүлэх
- Суралцагчийн чадамжийн хувьд боловсролын түвшин бүрт үе шаттайгаар үүрэг хүлээх, хариуцлагатай байх чадамжийг суулгах зааж, суурь чадвар болгох, бусдыг сонсож, илэрхийлэх чадамжийг нэмэгдүүлэх, дэлхийн болон үндэсний өв соёлыг сурталчлах, байгаль орчноо хайрлан хамгаалах дадал суулгах
- Багшийн хувьд хувь хүн, нийгмийн хөгжил, хэрэгцээг харгалзах, багшийн арга зүй дэмжих, мэргэжлийн байгууллагын хамтарсан сургалтын чанартай зохион байгуулах

Мөн хөтөлбөр боловсруулахад тусгах байгалийн ухаан суралцахуйн хүрээнд судлагдахууны хувилбаруудын саналыг нэгтгэв.

БИЕИЙН ТАМИР, ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРАЛЦАХУЙН ХҮРЭЭ



Хуралдаанд 21 аймаг, 9 дүүргээс хүрэлцэн ирсэн биеийн тамирын 50, эрүүл мэндийн 50 багш оролцлоо.

САЛБАР ХУРАЛДААНД:

“Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрийн суралцахуйн хүрээ” сэдвээр БСҮХ-ийн ЭША Х.Гэрэлцогт “Багшийн хөгжил” сэдвээр БЕГ-ын мэргэжилтэн н.Түвшинжаргал “Багш бэлтгэх хөтөлбөрийн шинэчлэл” сэдвээр МУБИС-ийн багш Л.Уртнасан, Э.Мөнгөтулга нар илтгэл хэлэлцүүлээ.



ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЯВЦАД

- Биеийн тамир болон эрүүл мэндийн багш нарын уялдаа холбоо, хамтран ажиллах орчин нөхцөлийг сайжруулах
- Судлагдахууны хөтөлбөр хоорондын уялдаа холбоог сайжруулах
- Багш нарын ур чадвар, арга зүйд дэмжлэг үзүүлэх олон саналууд гарч байлаа.

Салбар хуралдааныг хааж БСҮХ-ийн ЭНБД С.Санжаабадам оролцогч багш нарт зөвлөгөө өгөн, амжилт хүслээ.

“МОНГОЛ ХЭЛ” СУРАЛЦАХУЙН ХҮРЭЭ



“Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр” сэдэвт үндэсний хэлэлцүүлгийн “Монгол хэл”-ний суралцахуйн хүрээний хуралдаан МУБИС-ийн танхимд амжилттай зохион байгуулагдлаа. Тус салбар хэлэлцүүлэгт 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн БШУГ, НБГ, СӨБ-ын багш, ЕБС-ийн бага анги болон монгол хэл, бичгийн багш нарын нийт 120 гаруй төлөөлөл оролцлоо.



“Монгол хэлний суралцахуйн хүрээ” сэдвээр БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Оюунцэцэг, Д.Ганчимэг нар, “Багшийн хөгжил” сэдвээр БЕГ-ын ахлах мэргэжилтэн Д.Энхтулга, “Багш бэлтгэх хөтөлбөрийн шинэчлэл” сэдвээр МУБИС-ийн Багшийн сургуулийн захирал доктор Г.Бямбацэрэн, МУБИС-ийн Сургалт хамтын ажиллагааны газрын дарга, доктор Д.Соронзон нар мэдээлэл танилцуулж, тухайн чиглэл бүрээр тулгамдаж буй асуудал, шийдлийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэн санал солилцлоо.





БСҮХ-ээс удирдан чиглүүлсэн “Монгол хэлний суралцахуйн хүрээ” хэлэлцүүлгийн хүрээнд сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд тусгасан ерөнхий чадамжууд болон сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролд тодорхойлсон суралцахуйн хүрээ, улс орнууд эх хэлнийхээ суралцахуйн хүрээг хэрхэн тодорхойлсон, чадамжийг хэрхэн авч үзэж байгаа, манай улс чадамжийн тухай ойлголтыг хэзээнээс хэрхэн авч үзэж ирсэн, цаашид чадамжийг хэрхэн хөгжүүлэх тухай танилцууллаа. Оролцогчид “Монгол хэлний суралцахуйн хүрээ” нь сурагчдын дэлхийн болон үндэсний өв соёлоо ойлгох, хүндэтгэлтэй хандах, өвлөх, бүтээлчээр сэтгэх, шүүн тунгаах, харилцах, суралцахуйд суралцах зэрэг чадамжид илүү хувь нэмэр оруулна гэж үзсэн байна.

ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД

- СӨБ-ийн түвшинд тулгамдсан асуудал бол сургалтын орчин хэрэглэгдэхүүн, хүүхдийн хөгжлийн ялгаатай байдал, үүний шийдэл нь хүүхдийн насанд тохирсон хэл яриа хөгжүүлэх сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр дэмжих, шинэлэг арга зүйг нэвтрүүлэх, эцэг эх багшийн хамтын ажиллагаа гэж үзсэн байна.
- ЕБ-ын түвшинд сурах бичгийн агуулга, арга зүйг сайжруулах, анги дүүргэлт, багшийн ачаалал, зорилгод нийцсэн эхийн олдоц бага, үндэсний бичиг хичээлийн цаг бага гэсэн асуудал дэвшүүлсэн байна.

Эдгээр асуудлын хүрээнд оролцогчид сурагчийн эзэмших чадамжийг анги хооронд уялдуулах, бага ангийн сурах бичгийг улирлаар гаргах, дасгал ажлын дэвтэртэй болгох, монгол хүн төлөвлшүүлэхэд чиглэсэн унших эх зохиолын жагсаалт, сан бий болгох, хөтөлбөр сурах бичгийн уялдааг сайжруулах гэсэн шийдлүүдийг санал болгосон байна.

“ГАДААД ХЭЛ” СУРАЛЦАХУЙН ХҮРЭЭ



БСҮХ, БЕГ, МУБИС хамтарсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр” үндэсний хэлэлцүүлгийн гадаад хэлний салбар хэлэлцүүлэгт 21 аймаг, 9 дүүргийн 100 гаруй багш оролцлоо.

ТУС ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН ЗАРИМ САНАЛ:

Гадаад хэлний суралцахуйн хүрээний боломжит хувилбарын хүрээнд ихэнх багш нар бага боловсролд англи хэлийг III ангиас, суурь боловсролд Англи-Орос хэл заавал судлах хичээлээр оруулах, бүрэн дунд боловсрол: Англи-Орос заавал, Хятад болон бусад хэлийг сонгон болон төрөлжсөн хэлбэрээр сурагчдын эрэлт хэрэгцээнд түшиглэн бусад гадаад хэлийг сонгон суралцах асуудлыг сургууль өөрөө чөлөөтэй сонгох талаар санал нэгдэв.

Мөн англи хэлний ЭЕШ-ын оноог дүйцүүлэх IELTS-ийн 7.5 оноог 6.5 оноо болгон бууруулах, ЭЕШ-ын үнэлгээгээр сургууль, багш, аймгийг байр эзлүүлж дүгнэдэг асуудлыг болиулах чиглэлийг шийдвэр гаргах байгууллагаас дүрэм журамд тодорхой зохицуулалт хийж өгөх зэрэгт санал гаргав.

ТУС ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРСАН ЗАРИМ САНАЛ:

Гадаад хэлний суралцахуйн хүрээний боломжит хувилбарын хүрээнд ихэнх багш нар бага боловсролд англи хэлийг III ангиас, суурь боловсролд Англи-Орос хэл заавал судлах хичээлээр оруулах, бүрэн дунд боловсрол: Англи-Орос заавал, Хятад болон бусад хэлийг сонгон болон төрөлжсөн хэлбэрээр сурагчдын эрэлт хэрэгцээнд түшиглэн бусад гадаад хэлийг сонгон суралцах асуудлыг сургууль өөрөө чөлөөтэй сонгох талаар санал нэгдэв.

Мөн англи хэлний ЭЕШ-ын оноог дүйцүүлэх IELTS-ийн 7.5 оноог 6.5 оноо болгон бууруулах, ЭЕШ-ын үнэлгээгээр сургууль, багш, аймгийг байр эзлүүлж дүгнэдэг асуудлыг болиулах чиглэлийг шийдвэр гаргах байгууллагаас дүрэм журамд тодорхой зохицуулалт хийж өгөх зэрэгт санал гаргав.

БАГШИЙН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД:

- Багш нарт зориулж онлайн хэлбэрээр магистраа хамгаалах боломжоор хангах
- Тэгш боломж, багш солилцоо, гадаад харилцааг өргөжүүлэх
- Мэдээллийн сан нээлттэй байх
- Гадаад хэлний бэлтгэл сайжруулах
- Цахим, харилцааны технологид тасралтгүй суралцах орчин бүрдүүлэх
- Сурагчдыг амьдрах ухаанд сургах арга барилыг хөтөлбөрт уялдуулан оруулах

БАГШ БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨРИЙН ШИНЭЧЛЭЛ ГУРВАН ЧИГЛЭЛЭЭР

- Багш бэлтгэдэг сургуулиудын тоог багасгаж чанаржуулах
- Чанартай төгсөгч, багш бэлтгэдэг сургуулиудыг урамшуулах (стандарт хөтөлбөрийг ОУ-н түвшинд баталгаажуулах)
- Багш мэргэжлээр үнэ төлбөргүй сургах гэж байгаа бол босго оноог өсгөх
- Шалгуурт тэнцсэн чанартай их дээд сургуульд багш бэлтгэх лиценз олгох
- Дадлага хариуцсан багш, менежерт урамшуулал олгох саналаа нэгтгэж Монголын багш нарын VIII хуралд хүргүүлэв.

“НИЙГМИЙН УХААН” СУРАЛЦАХУЙН ХҮРЭЭ



Хуралдаанд 21 аймаг, 9 дүүргээс хүрэлцэн ирсэн түүх, нийгэм судлал, иргэний ёс зүйн боловсролын 100 орчим багш оролцлоо.

САЛБАР ХУРАЛДААНД:

1. “Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн “Нийгмийн ухаан” суралцахуйн хүрээ сэдвээр БСҮХ-ийн ЭША Г.Түвшинжаргал
2. “Багшийн хөгжил” сэдвээр БЕГ-ын багш, ажилтан, байгууллагын хөгжлийн газрын дарга. Р.Золзаяа.
3. “Багш бэлтгэх хөтөлбөрийн шинэчлэл” сэдвээр МУБИС-ийн багш С.Түмэндэлгэр, Х.Баярмаа нар мэдээлэл, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН:

“Нийгмийн ухаан” суралцахуйн хүрээгээр ямар чадамжийг хөгжүүлэх боломжтой эсэх, мөн агуулга, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүний хувьд ямар онцлогтой хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар хэлэлцэв.

Багшийн хөгжил, багш бэлтгэх тогтолцооны хувьд үндэсний түвшинд, орон нутгийн түвшинд, сургуулийн түвшинд, хувь хүний түвшинд тулгамдаж буй асуудлууд болон шийдвэрлэж болох боломжийн талаар санал бодлоо солилцов.

